



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 1642

Есөнбулаг

Үндэсний хувцасны өдөртэй  
болох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол үндэсний бахархал, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, соёлын дархлааг дэмжих зорилгоор сар бүрийн 01-ний өдрийг "Үндэсний хувцасны өдөр" болгохоор тогтсугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, сурталчлан, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар (С.Цагаанбаатар), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар) нарт, аймгийн Төрийн байгууллагуудын албан хаагчдыг үндэсний хувцсыг нь өмсүүлж хэвшүүлэхийг Төрийн захиргааны Удирдлагын хэлтэс (Я.Жаргалцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (С.Мөнхжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ